

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3621>

Article | Fasc.6

## Хүннүгийн газрын харилцааны онцлог чанар нь монголчуудын сэтгэлгээний үндэс болох тухайд

Ондоогийн Болор-Эрдэнэ

Шаньдун их сургууль, Жинань муж, Бүгд Найрамдах Хятад Ард Улс  
ORCID: <https://orcid.org/0009-0005-0881-1232>  
Холбоо барих зохиогч: [bbbirdist11@gmail.com](mailto:bbbirdist11@gmail.com)

**Хураангуй:** Хүннү нь монгол газар нутагт байгуулагдсан анхны төрт улс агаад Хүннү гүрэн байгуулагдсан нь төв ази дахь тал нутгийн эртний нүүдэлчдийн соёл иргэншлийг нэг үндэстний тугийн дор нэгтгэсэн түүхэн мөчлөг үе юм. Монголчууд Хүннү гүрнээс төрийн улбааг авсан хэмээн төрийн түүх, онол талаас харж буй ч бид хүннүгээс төрт ёсны уламжлалаар дамжуулаад бүхэл бүтэн нүүдлийн бие даасан төр-соёл-иргэншлийг нь уламжилж авсан билээ. Хүннү гүрний угсаа, соёл, нийгмийн бүтэц, төрийн удирдлагын бүтэц тогтолцоо, аж ахуй зэрэг нь цогцоор авч үзэх шаардлагатай цогц байгууламж бөгөөд гол зарчим нь байгалийн жамд нийцсэн “ёс”-нд тулгуурласан зарчимтай байв. Уг ёс нь нийт хүннүгийн нийгмийг бүрхсэн цэрэг-захиргааны тогтолцоогоор дамжиж хэрэгждэг байсан бөгөөд эл зарчим нь “тэнгэрийн ёс”-ны ойлголтоор дамжин сэтгэлгээний хийсвэр дээд түвшинд хүртлээ хөгжсөн нь өнөөгийн монголчуудын сэтгэлгээний язгуур чанар билээ. Тиймд угсаатны сэтгэлгээний язгуур чанарын уламжлалаар бол Хүннү гүрэн нь өнөөгийн монголчуудын шууд өвөг мөн юм.

**Түлхүүр үгс:** *газар нутаг, ёс, ёс заншил, төрт ёс, тэнгэрчлэл*

### The Hunnu's land relations: A characteristic of Mongolian thoughts /Xiongnu/

Bolor-Erdene Ondoo

Fine Arts School of Shandong University, China  
ORCID: <https://orcid.org/0009-0005-0881-1232>  
Corresponding author: [bbbirdist11@gmail.com](mailto:bbbirdist11@gmail.com)

**Abstract:** The Hunnu Empire is the first-ever statehood established in the territory of Mongolia, and the period of establishment of the Hunnu Empire is the historical period when the ancient nomads in Central Asia united all of their civilization under the flag of one nation. Although, according to explanations in the history and theory of the state, the Mongolians derived the path to statehood from the Hunnu Empire, in



fact, we derived independent state-culture-civilization from the Hunnu Empire through the statehood tradition. The national origin, culture, social structure, state structure, and system, as well as the economy, are the comprehensive structure to be considered as a whole and complex, and the fundamental principle was based on legislation and old customs promoted by the law of nature. These legislation and old customs were realized through the military-administrative system broadly spread in the Hunnu society, and this principle has been developed to the highest-order thoughts through the “spiritual order”. This is the fundamental essence of thoughts for today’s Mongolians. Accordingly, we can say that the Huns are the ancestors of modern Mongolians as per the tradition of the fundamental essence of national thoughts.

**Keywords:** *land, legislation, customs, statehood, tenggerization*

### Оршил

Хүннү (НТӨ 209 – НТ 93 он) гүрнийг бичиг үсэгтэй байсан хэмээн үздэг ч монголчуудтай угсаа гарлын хувьд шууд холбоотой, бидний өвөг гэж хүлээн зөвшөөрөхөд бичгийн ямар нэг дурсгал хараахан олдоогүй учир түүхийн маргаантай асуудал байсаар байгаа юм. Энэ нь шинжлэх ухааны хүрээнд баримтаар нотлогдох шаардлагатай асуудал мөн ч гэлээ хүннүчүүдтэй холбоотой монгол нутгаас олдож буй археологийн олдворуудад үндэслэн судлаачид хүннү нь монголчуудын өвөг гэдэгтэй санал нэгддэг. Харин төр, эрх зүйн хувьд төрийн тогтолцоо, засаг захиргааны зохион байгуулалт нь хүннүгээс дараа дараагийн улсуудад уламжлагдсаар өнөөгийн Монгол Улсын төр захиргааны тогтолцоо, төрт ёсны үндсэн суурь хэмжүүр болсон нь эх сурвалжийн баримтаар нотлогдсон түүхэн үнэн юм.

Улсын тухай орчин үеийн ойлголтод “төр” гэдгийг газар нутаг, хүн ам, төрийн засаглалтай байх үндсэн шинжүүдтэй байна гэж үзжээ. Энэхүү газар нутаг зайлшгүй байх үндсэн нөхцөл нь өрнийн төрийн онолд XIX зуунаас дурдагдаж эхэлсэн бөгөөд “...хэр чухал, зайлшгүй зүйл болохыг зөвхөн XIX зуунд ухаарч, үүнээс өмнөх үеийн тодорхойлолтуудад нутаг дэвсгэрийн тухай ер зааж тэмдэглээгүй нь ихээхэн сонин юм” (Лүндэндорж 2002, 85) гэжээ. Өрнийн суурьшмал сэтгэлгээнд “улс” гэх ойлголт нь цайзаар хүрээлэгдсэн хот улсын хэмжээнд ойлгогдож байсан бөгөөд эл сэтгэлгээнээс тал нутгийн нүүдэлчдийн бий болгосон улсын тухай ойлголтын эх сэтгэлгээ нь эрс ялгаатайг анзаарч болно. Тал нутгийн нүүдэлчдийн хувьд газар нутаг хичнээн чухал байсныг хүннүгийн шаньюйн “Газар бол улсын үндэс” хэмээх үг тодорхойлдог. Хүннү нь газар нутгийн хувьд өмнө зүгт Цагаан хэрэм, Ордос, хойгуураа Байгаль нуур, баруун тийш Ил тарвагатай, Шинэ хязгаар, зүүн тийш умард солонгос хүрч байв. Модунь шаньюй 24 аймгийг нэгтгэн төв азийн өргөн уудам тал нутаг дэвсгэр буюу дэлхийн хамгийн том тэгш талыг хамарсан эзэнт гүрнийг байгуулсан бөгөөд төрт улсын эрх зүйн орчин, эрх зүйн онолын хүрээнд үзвэл, өөрийн нутаг дэвсгэрийн хил хязгаарын дотор үйлчилдэг хэв хуультай, цэрэг-захиргааны хосолсон засаглалтай, гадаад харилцаа, худалдаа хөгжсөн, бүрэн эрхт төр бүхий асар том эзэнт гүрний засаглалтай хүчирхэг гүрэн байв.

“Угсаатны сэтгэлгээний адилсал бүрэлдэх нь өөрийгөө тухайн овог аймагт харьяалуулах сэтгэлгээнээс тухайн угсаатан, ард түмэнд харьяалуулах ойлголт сэтгэлгээ төлөвших үйл явц бөгөөд нэг хэл, соёл, зан заншил, газар нутагтай байж, нэгдмэл нэг угсаа гарлын тухай ойлголт төлөвших нь угсаатны сэтгэлгээний адилсал бүрэлдэх нэгэн гол нөхцөл гэж үзэж болох юм” (Монгол Улсын их сургууль 2017, 103) хэмээн улс төр, эрх зүйн онолд авч үзэх нь бий. Энд дурьдаж буй “... өөрийгөө тухайн угсаатан, ард түмэнд харьяалуулах” гэдгийг тухайн угсаатны сэтгэлгээний ялгарах чанарыг ухамсарлах үйл явц гэж хэлж болно. Энэ сэтгэлгээний ялгаатай чанар төлөвшихөд тухайн бүс нутгийн газар зүйн онцлог, нэг хэл, нэгдсэн ахуйн соёлтой байх бөгөөд ...эдгээр адилсал бий болоход улс төрийн нэгдэл буюу нэгэн төрийн дор нэгдэн, төр улс бий болох нь нөлөөтэй гэж үздэг.” (Монгол Улсын их сургууль 2017, 103) Түүнчлэн төр улс гэдэг нь тухайн угсаатныг сэтгэлгээ болоод газар нутгаар нэгдсэн нэг тогтолцоонд хамруулж, нэгдсэн нэг бүхэллэг нийгэм-соёлын тогтолцоог бий болгохыг ойлгож болох бөгөөд энэ нь төр улс үүсэх түүхэн нөхцөл, үйл явцтай давхцаж, төрт улс бий болж засаг захиргааны нэгж, газар нутгийн хуваарилалт, засаглалын бүтэц хэлбэрээр нэгэн бүхэллэг соёлын хүрээ хязгаарыг тогтоож өгч буй угсаатны өөрийн дотоод нэгдмэл хүчний илрэл юм.

Нэгэнт монголчууд Хүннү гүрнээс төрийн уламжлалаа авсан юм бол уг төрийн уламжлал нь Хүннү гүрний үед ямар агуулгаар оршиж байсан болон тухайн төр нь том агуулгаараа угсаатны соёлын ямар бүрдэл, ямар улбааг агуулж байсан бэ? Тэр улбаа нь сэтгэлгээний хувьд хаанаас эхтэй, юуг илэрхийлдэг, бидний сэтгэлгээнд хэрхэн уламжлагдаж ирсэн гэдгийг тодруулахад энэхүү өгүүллийн гол зорилго оршино. Энэ нь монгол үндэстний язгуур сэтгэлгээний дотоод хүчин зүйл, түүний холбоо хамаарлыг цогц байдлаар ойлгоход чухал хэмээн үзэж буй билээ.

### **Судалгааны арга зүй**

Өрнө бус соёлыг нийтэд нь хамруулаад дорнын соёлд багтааж үздэг үзэл нэгэнт тогтчихсон. Энэ нь нэг талаар бидний хувьд, ялангуяа өнөөдрийн дорнын бусад соёлын түрэмгийлэл хүчтэй болсон үед бид өөрсдөө суурь судалгааны ертөнцөд энэ үгийг авч хэрэглэн, түүнд өөрсдийгөө багтаан хамаатуулах нь тийм ч тохиромжтой бус байж мэдэх юм. Уг асуудлын цаана хэрхэн ойлгохуйн тухай асуудал байх агаад бид өөрсдөө соёлоо томьёолох, хүрээ хязгаар, гарал үүслийн ойлголтыг нэг чигтэй болгох, түүний дотоод бүтэц, дотоод язгуур чанар, ялгаатай шинжийг өөрийнх нь дотоод зүй тогтлынх нь дагуу тайлах шаардлагыг бий болгож буй билээ. Тиймээс монголчуудын соёл иргэншил, тал нутгийн ертөнц, түүний язгуур сэтгэлгээ нь “Монгол” гэх нэр үүсэхээс эхлэх бус энэ газар, бүс нутагт хүн үүсэж амьдарч эхэлсэн цаг мөчөөс эхлэлтэй байхын зэрэгцээ тасралтгүй үргэлжилсээр ирсэн түүхэн судал жим агаад, түүнийг бусад соёл иргэншилтэй харьцуулан аль нэг онол номлолын хам хүрээнд багтаан тайлбарлахыг хойш тавин, тусгаар дангаарт нь төрт ёсны уламжлалынх нь хүрээнд задлан шинжилж, нэг урсгалд оруулах оролдлого хийв.

Тэгэхдээ дан ганц соёл, иргэншил, урлаг эсвэл төр захиргааны зохион байгуулалтыг ганцхан эзэнт гүрний оршин тогтносон цаг хугацаанд хамааруулан авч үзэж, нүүдэлчид гэх ерөнхий айд багтаан, нүүдэлчин үндэстэн ямар боловч

бусдаас өөр, онцгой хэмээн тоочих, тухайн нийгэм дэх үзэгдлийн чанартай гадны нөлөөллийг онцлохыг урьтал болгосонгүй.

Төв азийн тал нутгийн нүүдэлчдийн анхны төрт улс хэмээн түүхэнд бичигдэж үлдсэн, бидэнд төрт ёсны уламжлал нь өвлөгдөөд ирчихсэн Хүннү гүрнийг голлон, түүнээс өмнө хэрхэн бүрэлдсэн урьдач нөхцөл болон түүнээс хойш бидэнд хэрхэн уламжлагдаж ирснийг тодруулах зорилгын хүрээнд түүний тусгаар шинжид үндэслэн язгуур үүсэл, түүнийг бүрдүүлэгч организмуудыг нэгдмэл системийн байдлаар тоймлон, ингэж авч үзэхийн тулд философийн герменевтик аргыг ерөнхий чигээ болгов. Уг өгүүлэл нь түүхийн баримт материал болон судлаач, эрдэмтдийн судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн, тэдгээрийн түүхэн он дарааллаар харьцуулах болон утга зүйн шинжилгээ хийх, нэгтгэх замаар бичигдсэн болно.

### Судалгааны үр дүн

#### 1. Газар-Газар нутаг-Байгалийн жам ёсны тухайд

Модунь шаньюйн “Газар бол улсын оршин тогтнох үндсийн үндэс. Яахин өгч болно” (地者, 国之本也, 奈何予之) хэмээх зарлигаас

Тэр газар соёлсон соёл яахсан билээ?

Тэр газрын онцлогоор бүрэлдсэн хүний ахуй, оршихуй хэрхэх билээ? гэх асуултуудын хариултыг нүүдэлчид их эртнээс ухаарсан байсан нь илт. Хүннүчүүдийн гол эрхлэх аж ахуй нь сонгодог түвшинд хүртлээ хөгжсөн МАА байсан учир тэдний эрхлэх аж ахуйгаас хамааран газартай харьцах, эзэмших байдал, ер газрын талаарх ойлголт нь жилийн дөрвөн улирал буурь, бэлчээр сэлгэн нүүдэллэдэг, сонгодог нүүдлийн соёлынх нь суурь ухамсарт оршиж байв.

Хүннүчүүдийн НТӨ 121 онд зохиосон дуунд “Цилинь уулаан алдаад зургаан хошуу мал минь өсөхөө болилоо, Яньчи уулаан алдаад авгай нар минь энгэсэггүй боллоо” мөн “Хань улсын сударт”-т Ужүлэ шаньюй Хань улсын элчийн хүннүгийн газар нутгаас авах санаархлын хариуд Хань улсын хаанд мэдүүлсэн заргын бичигт “Эцэг, ахаас таван үе болжээ. Хань улсаас энэ газрыг асуугаагүй билээ. Өнөө юу болоод энэ газрыг хүсээд байна? ...Хүннүгийн баруун хилийн олон ноёд гэр, тэрэг хийхэд энэ уулын модыг ашигладаг, энэ бол дээдсийн газар болохоор манай нутгийн нэг хэсэг” хэмээсэнд Хань улсын хаан: “Фань дураараа зарлиг хэмээн шаньюйгаас газар авна гэсэн нь хуулиар бол цаазлах ялтай...” (Дэлгэржаргал ба Батсайхан 2017, 121, 125) хэмээн хариу зарлиг гарган илгээжээ. Энд хүннүгийн шаньюй тухайн газрыг ямар учиртай газар болохыг онцлоод “дээдсийн газар” хэмээснийг анхаарах учиртай. Мөн Модунь шаньюйн “авын газар” (Сүхбаатар 1980, 64) гэж байсан зэргээс үзвэл, газар болон газар нутаг түүний баялаг нь аж ахуйн болоод соёлын ахуйн ач холбогдлыг машинд чухалчилж үзэхийн зэрэгцээ энэ бол удмын хэлхээ, удмын санг илэрхийлэх, түүнийг илэрхийлэх үнэт зүйл аж. Наашлаад “Их засаг” хуульд “Өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаагсдын нэгэн гэрийг алмой” (Лхамсүрэн 2002, 20) зэрэг газар хамгаалах хуультай бөгөөд МНТ-д бичсэнээр, Монголын эзэнт гүрний үед нутаг дархлан тогтоодог байсан нь хүннүгээс уламжилж авсан уламжлал юм. Энэхүү газрыг эртнээс амьдарч ирсэн өвөг дээдэстэйгээ холбон хүндлэн, дархалж ирсэн заншил нь өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн байдаг. Түүнчлэн Л.Н.Гумилев байгаль

орчны нөхцөл байдал, газар зүйн байршил угсаатныг бий болгодог суурь хүчин зүйл гээд хүний биологийн хүчин зүйлийн нөлөө, хамаарлыг нийгмийн хүчин зүйлээс дээгүүрт тавьж “Янз бүрийн аж ахуйн дадал, шашин шүтлэг, нийгмийн байгууламж, зан үйл бүхий үй түмэн овог аймгаар дүүрсэн газар зүйн нэг бүхэлдэл хэсгийг оршин суугчид нь яалаа ч гэсэн ямар нэгэн нэгдэл юм гэж мэдэрдэг байв” гэж тэмдэглэсэн нь нүүдэлчдийн тухайн газрын оршин суугчид овог болон хамтаар нэгдэн нүүдэллэдэг тал нутгийн нийгмийн бүлгийн үндсэн шинжийг тодорхойлсон чухал дүгнэлт юм.

Цаашлаад “Хүннүгийн үед засаг захиргааг газар нутгаар хувааж байсан уу, хүн амаар хувааж байсан уу гэдгийг тодруулах сурвалжийн багтай баримт одоогоор олдохгүй байна” гээд “Гэвч хожмын уламжлал болон хүннү нар улсаа баруун зүүн гар, төв гэсэн газар нутгийн зохион байгуулалтаар хувааж байснаас үзвэл, хүннүгийн үед ч гэсэн аравтын тогтолцоог газар нутгаар хувааж байсан гэж үзэж болно” (Дэлгэржаргал ба Батсайхан 2017, 156) хэмээн тэмдэглэжээ. Харин “Түүхэн тэмдэглэл”-ийн хүннүгийн шаштирт: “Зүүн түшмэд болон жанжид зүүн талд, Шангу (上谷Shanggu) эсрэг талд ба түүнээс цааш, зүүн талаараа Хуйхэ (秽貉Huihe), (朝鮮Chaoxian) зэрэгтэй хиллэн суудаг, баруун түшмэд болон жанжид баруун талд... шаньюйгийн өргөө Дай, Юньчжун эсрэг талд байрлана. Өвс усны аясыг даган амьдардаг ба бүгд хуваарьт эдэлбэр газартай, эдгээрээс хамгийн том зүүн ба баруун сянь вангууд болон зүүн ба баруун лули вангууд эзэмшдэг” (СыМа Цянь 2014, 48) хэмээсэн байх бөгөөд энд баруун зүүн түшмэд, төв хэсгийг нутгийн баруун зүүн төв хэсгээр хуваан, хилийн зурвасыг нарийн зааснаас үзвэл, газар нутаг, хүн ардын нутагладаг бүс нутгаар нь хуваарилсан хуваарь гэж үзэж болох ноттой баримт мөн болно. Түүнчлэн эрдэмтэн Г.Сүхбаатар хүннүгийн газар эзэмшлийн талаар хятад болон бусад эх сурвалжийн мэдээнд үндэслэн “Хүннү мэтийн хувь газар гэж түмтийн дарга нар гэх ерөнхий нэрээр нэрлэгдсэн ван, жанжин нарын захиргаанд байсан нутгийг ойлгох хэрэгтэй нь бүрэн тодорхой байна” (Сүхбаатар 1980, 63) гэж тэмдэглэсэн нь засаг захиргааны нэгж, төрийн удирдлагын тогтолцооны шатлалаар тайлбарлагдах агаад газар нутгийн хэмжээ нь малын тоотой харгалздаг болохыг Рубрук “Дарга бүр олон буюу цөөн хүн захирч байгаагаас харгалзан бэлчээрийнхээ хязгаарыг тэрчлэн өвөл, зун, хавар, намар малаа хаана бэлчээрлүүлэх ёстойгоо мэддэг” (Сүхбаатар 1980, 64) гэж бичсэн зэргээс үзвэл, үндсэн аж ахуйнхаа онцлогт захирагдсан хуваарилалт мөн боловч аж ахуй нь газар нутаг, байгалийн онцлогтоо зохицох, хуваарилан харах шаардлагад хүргэж буй явдал юм. Тэд саахалтын 5-10 айл өрхөөр нэгэн бүл болж нүүдэллэдэг, нэг аравтын бүрэлдэхүүний 10 цэргийг бүрдүүлдэг зэрэг сурвалжийн мэдээ нь дээрх баримтыг давхар баталж буй хэрэг билээ.

Мөн Чжунхан Юэ тайганы Ханьгийн элчид хэлсэн “Хүннүчүүд дайныг үндсэн ажлаа гэж боддог, харин хөгшин сул дорой хүмүүс дайтаж чадахгүй учир тэд эрүүл чийрэг залуусаа хамгийн чанартай хоол хүнсээр хооллон ундалснаар нэг ёсондоо өөрсдийгөө хамгаалж байна гэсэн үг юм” (Сүхбаатар 1980, 64) гэсэн нь хил хамгаалах, газар нутгаа хамгаалах цэргийн албаны чухлыг, түүнд улсын иргэн бүр хамаатайг тодруулжээ. Хүннүгийн шийтгэх ёсонд “нутаг заан цөлөх” шийтгэл байсан нь тухайн нутагт очоод ямар байдалтай байх нь тодорхойгүй боловч хүннүд

хэдхэн өдрийн хорих ял байсан учир энэ нь удаан хугацаагаар шийтгэхийн тулд нутгаас нь хол явуулах, хүний нутагт илгээх утга агуулдаг байсан байж болох. Тийм гэж үзвэл, мөн л газар нутагтай холбоотой, өөрийн төрсөн нутгаас нь хол цөлөх агуулга бүхий утгатай шийтгэл гэж болно. Энэ тухайд Чингис хааны сургаалд “Ураг удмынхан дотроос хэн нэгэн нь Засаг хуулийг нэгэнтээ зөрчин үйлдвээс үгээр зөвлөн сануулагтун; хоёр дахин зөрчих аваас сайтар ятган ухуулсугай; гурав дахь удаад түүнийг алс хол орших Балжин хужир тийш илгээсүгэй” (Вернадский Г В. 2015, 81, 27) гэснээс уг шийтгэлийн уламжлалыг тодорхой харж болохоор байна. Тиймээс хүннү нүүдэлчдийн хувьд “нутаг”, “нутаг дэвсгэр”, “газар нутаг” гэх ойлголтууд нь тус тусдаа утга бүхий ойлголтууд байх агаад тал нутаг түүний газар зүйн орчин нь тэдний бие сэтгэлээрээ нэгдсэн оршихуйн үндэс нь болж байна.

Дээрхээс үзвэл, хүннүчүүдийн хувьд газар нь улсын өмч, газар нутаг нь нийт “ард түмний өмч”, улсын тусгаар тогтнол нь нүүдэлчдийн “газар-нутаг төвт” “хүний эрх”-ийн ойлголтоор тодорхойлогдож байгаа бөгөөд үүнийг өнөөгийн газрын тухай хуульд “Газартай харьцах нь хүний заяамал эрх” (Сэнгэдорж 2002, 46) хэмээн заажээ. Харин төр эрхийнхээ хүрээнд тэр заяагдмал эрхийг нь хамгаалах учиртай аж. Ийнхүү тал нутгийн эртний нүүдэлчдийн хувьд, хүннүчүүдийн хувьд газар-нутаг гэдэг тэдний өгөгдлийн заяамал язгуур нөхцөл болохын зэрэгцээ сэтгэлгээнийх нь язгуур үндсийг нөхцөлдүүлэн бүрэлдүүлэгч, эрх, эрх чөлөөнийх нь илэрхийлэл, хил хязгаарын баримжаа болж буй юм. Тиймээс төв азийн нүүдэлчин монголчуудын хувьд “газар-нутаг” гэдэг энэ газар нутагт хүн анхлан амьдарч эхэлсэн цагаас амьдралаараа ухамсарласан “жам ёс”-ны зүйл болж буйг чухалчлан үзэх учиртай.

## 2. Төр- Төрт ёсны тухайд

*Нийгмийн байгуулал, түүний бүрэлдлийн тухай авч үзэх нь:* Хүннүгийн төр захиргааны тогтолцоо нь цэрэг-захиргааны шатлан захирах аравтын тогтолцоо бөгөөд газар-нутагт суурилсан, нийт ард түмнийг хамарч тор мэт сүлжсэн, цэргийн хатуу сахилга бат бүхий төгс боловсруулсан “ёст” тогтолцоо байв. Дээр өгүүлсэнчлэн 5-10 айл нэг аравт цэрэг гаргах үүрэгтэй ба аравт гаргах боломжтой айл өрхийн нэгдэл нь нийгмийн байгууллын хамгийн жижиг нэгж болж байсан гэж үзэх боломжтой. “Хүннүгийн шастир”-г бичсэнээр, хүннүгийн эртний газар нутаг дээр Ся (夏) хэмээх улс оршин тогтнож байсан, тэдний хойчийн улс хүннү гээд хүннүгийн оршин тогтносон хугацааг “Шунвэйн үеэс Түмэнгийн үе хүртэл мянга гаруй жил өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд [Хүннүчүүд] зарим үед хүчирхэгжиж, зарим үед хүч нь доройтон бутарч байв” (СыМа Цянь 2014, 47) гэснээс үзвэл, хүннү нь Модунь шаньюйн байгуулж, түүхэнд бичигдэж үлдсэн л улс болохоос нүүдэлчдийн анхны төр, төрт ёсны эхлэл бол биш юм. Харин хүннү нь наанадаж НТӨ II мянганаас НТӨ I мянганы эхнээс оршин тогтнож байсан, хүннүг бүрдүүлсэн аймгууд нь НТӨ II мянганы эхэнд хүчирхэг аймгийн холбоонд шилжсэн гэж түүхчид үздэг. Түүнчлэн судлаачид түүхийн эх сурвалжид гардаг хүннү нэрийн тухайд авч үзээд, “НТӨ III мянганд хүннү аймгууд хүчирхэгжсэн байсан гэж санал нэгдэж, эдгээр аймгууд боловсронгуй хүрэл зэвсэгтэй, морьт цэрэгтэй байсан” (Монгол Улсын их сургууль 2003, 184) хэмээжээ. Мөн хүннүгийн төр бүрэлдсэн

түүхэн цаг хугацааг хүннү судлаач Г.Сүхбаатар зарим сурвалжид үндэслэн “НТӨ III мянган жилд хятад, энэтхэг, вавилоны зүгийн иргэншлийн нөлөө бүхий нутгийн аймагтай хөрш байсны хувьд дэлгэр харилцаатай байх ёстой” (Сүхбаатар 1980, 157) гэж тэмдэглэсэн нь тэдгээр аймгууд нийгмийн байгууллын хувьд нэлээд хөгжингүй байсныг тодотгож буй. Тал нутгийн нүүдэлчдийн хувьд морьт цэрэгтэй, зэвсэгтэй болсон гэдэг нь нийгмийн зохион байгуулалт, удирдлагын тогтолцооны хувьд нэлээн боловсронгуй түвшинд очсон дүр зураг төдийгүй НТӨ III мянганы тэртээх аймгийн хэмжээнд хүннүгийн цэрэг-захиргааны тогтолцооны уламжлал аль хэдийнэ бүрэлдсэн байсан гэж үзэж болно. Харин аймгуудын холбоо, аймаг үүсэхээс өмнөх үед нүүдэлчдийн нийгмийн байгуулалт нь цусан төрлөөр холбогдсон овог аймгийн байгуулалттай, феодалын нийгэм байсан гэж үзэх нь бий. Гэвч хүннүгийн түүх бичлэг нь өрнийн түүхчдийн анхлан бичсэнээр эхэлсэн нь нэршлийн хувьд зөрүүтэй байх магадлал их бий юм. Учир нь өрнийн түүхчид өөрсдийн түүхийн судалгааны аргачлал, түүхийн үечлэлийн талаас харж бичсэн нь хүннүгийн түүхийн нэршлийг болон утгыг андуурсан, хятад түүхийн сурвалжаас буулгахдаа өөрсдийн түүхийн нэршилд хөрвүүлэн буулгаж ойлгосонд байна. “Түүхэн тэмдэглэл”-д хүннүгийн Хуянь (呼衍氏 Hu yan shi), Лянь (兰氏 Lan shi), Сюйбу (须卜氏 Xu bo shi) (СыМа Цянь 2014, 47), (司马迁 无日期) зэрэг сурвалжит овог гарах бөгөөд эдгээр нь хүннүгээс өмнө оршиж байсан удам угсааны сурвалжит удмын овгууд болно. Мөн монголын эртний түүхийн “Хүннү” зохиолд хятад сурвалж болох “Хожуу Хань улсын судар”-ын “Өмнөд хүннүгийн шастир”-т бичсэнийг үндэслэн шаньюйн гарлын талаар бичихдээ хэрэглэсэн син ши (姓氏 xing shi)-г овог аймаг гэж орчуулж ирсэн нь “...Хүннүг “овог аймгийн нийгэм”-ийн (tribe, clan) зохион байгуулалттай хэмээн ойлгох үндэс болсон” гэж үзжээ. “Түүхэн тэмдэглэл”-д шаньюйн гарал болон хойших удмын талаар бичсэнчлэн 姓 (xing), 氏 (shi), 族 (zu), 部落 (bu luo), 貴種 (gui zhong), 種姓 (Zhong xing), 貴人 (gui ren) (司马迁 无日期) зэрэг үгс нь 家族血缘 (jia zu xue yuan) буюу нэг ураг, цусан төрлийн холбоог заасан болно. Энд шаньюйн язгуур удам угсааг бичсэн бөгөөд сурвалжит, язгууртан гэр бүлийн угсаа залгамжийг хэлжээ.

Харин судлаач С.Өлзийбаяр “Хожуу Хань улсын судар”-т Ухуаньчуудын талаар бичсэнд болон бусад судлаачдын саналд үндэслэн, судлаачдын аймаг, бүлэг, овог хэмээн ойлгож ирсэн 部落/bu luo/ гэх ханзыг монгол хэлний төрсөн эгч дүүсийн хүүхдүүдийг нэрлэдэг “бүл” хэмээх үг гээд, эртний нүүдэлчдийн нийгмийн байгууллын анхдагч зохион байгуулалтын хэлбэр нь булуо 部落 буюу бүл байсан гэж үзжээ. Уг бүл нь эхийн талыг баримтлах хүйн холбоо бөгөөд “...бүлийн дотор нүүдэлчдийн төр улсын үндэс болсон язгууртны бүлэг буюу ураг (шаньюйн, мугулуй, ашина гэх мэт)-ууд үүсч байсан” (Өлзийбаяр 2017, 50) улмаар уг ургийг даган эхийн эрхт ёсны эхийн талыг барьсан бүл нь өмч хөрөнгөтэй холбоотойгоор эцгийн талын ясан төрлийг дагасан “овог” болж, удам залгах болсон бөгөөд “...эд өвлөгдөх болсон цагаас түүнийг өвлөгчдийн нэгдлийг нэрлэх “obog” нь гарлын хувьд хөрөнгийн өв (öb)-өөс үүдэлтэй байж болох юм. Явцын дунд хөрөнгө өвлүүлэгч этгээдийг öböг (ebuge бус) гэх болсон нь “овог”-ийн төдийгүй өвөг/ebuge дээдсийн ч нэр болжээ” (Өлзийбаяр 2017, 59) хэмээн нотолжээ. Овгийн байгуулалт нь бүл дотор үүсэж буй ургаас үүссэн төрлийн холбоо хамаарал байхаас гадна,

эд хөрөнгийн хамаарал бүхий холбоо бөгөөд язгууртан ургийн болон тэдгээрийн угсаа залгамжлалын хэлбэр болж байна.

Тэрээр бас нэгэн чухал мэдээлэл дурдсан нь баруун Ханьгийн судар болон Лян улсын сударт тэмдэглэсэнд үндэслэн, “нүүдэлчдийн төр улс тогтож, төрийн харилцаа гүнзгийрэхэд “бүл”-ийн зохион байгуулалт эвдэгдэж, харин задарсны дараа дахин идэвхжиж байсныг харуулж байна” (Өлзийбаяр 2017, 57) гэсэн нь нүүдэлчдийн төр, төрт ёс бүрэлдэх үйл явцыг тодорхойлох чухал баримт юм. Эртний нүүдэлчдийн бүлийн зохион байгуулалтаас эцгийн талын овгийн байгуулалд шилжих замаар төр үүсэж, төлөвшиж ирсэн гэсэн үг. Энэ нь бүр эртний хүй нэгдлийн үеэс аажим нэгдэж, задарсаар төрийн тогтолцоо бүрэлдэх урт хугацааны төлөвших үйл явцын үр дүн юм. Эндээс нүүдэлчдийн төр бүрэлдэх үндэс нь бүлийн дундаас үүссэн ургийн үүсэлтэй холбоотой бөгөөд эцгийн талыг дагаж төр, төрт ёс үүссэн болохыг харж болно. Энэ бол хүний болоод нэг бүлэгт хамаарах хүн амын язгуур мөн чанар, түүний нийлэмж, зохицол, ахуйн соёлын нөхцөл дээр жамаараа үүсэж буй үндэстний төр, төрт ёс бүрэлдэх үйл явц бөгөөд монголчуудын “газар эх, тэнгэр эцэг”-ийн ойлголтын үүсэлд дүйцүүлж болох юм. Эхийн эрхт ёсны бүлээс ураг үүсэж бүрэн хэлбэрээ олж тогтсоноор нийгмийн бүлэгт удирдлагын өөрчлөлт орж, овог үүссэнээр түүний залгамж холбооны зарчим дээр төр үүсэж, төрт ёс бэхжиж, газар нутгийн цар хүрээгээрээ илүү томорч, аймаг үүсэж эхэлсэн гэж харж болохоор байна.

Нийгмийн байгууллын жижиг нэгж болохын тухайд, “Було/бүл-ийг ийнхүү аймаг, хүрээ гэж олон судлаачид тайлбарласан ч бүлийн байгууллын үеийн хүрээг нүүдлийн мал аж ахуй эрхлэлтийн онцлогоос үүдэн бий болсон хөдөлмөр зохион байгуулалтын нэгэн өвөрмөц хэлбэр гэж үзэх нь зүйтэй мэт.” (Өлзийбаяр 2017, 55) гээд “Хүрээ нь бүлийн үед малчин нүүдэлчид хөдөлмөр, хүчээ хорших зохион байгуулалтын төгс шалгарсан хэлбэр байсан бол аажим хувийн өмч бүхий ило/айлаар төвлөрсөн овгийн байгуулал тогтох үед хөдөлмөр зохион байгуулалтын үндсэн шинжээ алдаагүй ч үүний зэрэгцээ ихэс, дээдсийн орд өргөөг хамгаалах хэлбэр бүхий улс төрийн төв болж агуулга нь баяжсан байна” (Өлзийбаяр 2017, 56) гэсэн нь аж ахуйгаа дагасан газар-нутагт суурилсан нийгмийн байгууллын бүрэлдэх, төлөвших, хэлбэржих үйл явц нь боловсронгуй түвшинд хүрч, төр улсын нийгмийн тогтолцоо болж ирж байна. Энд нийгмийн байгууллын жижиг нэгж нь хүрээ бөгөөд өрхүүд хүрээгээр бууж, айлаар нүүдэллэдэг нь дээр дурдсанчлан эртний нүүдэлчдийн нийгмийн байгууллын хамгийн жижиг нэгж нь өрхүүдийн нэгдэл байсан гэдгийг баталж буй бөгөөд бүлгийн дотоод нэгдлийн холбоо хамаарал, түүнээс салбарласан нэгдэл, удирдлагын тогтолцоо нь аажмаар давхарга үүсгэж төлөвшиж байсан ч МАА-тайгаа уялдаж, улирлын нөхцөлдөө тохируулан бүл дотроо хүрээ үүсгэн, хойшид овог дотроо ч энэ хэлбэрийн өрхийн нэгдлээрээ нүүдэллэн аж төрж, тэр нь тухайн нутаг усандаа газар нутгийн хуваарилалтаар явагддаг үйл явц байсан нь энд маш тодорхой байна. Уг хүрээний хэлбэр нь өнөөг хүртэл үндсэн хэлбэрээрээ уламжлагдан ирснийг мөн тэмдэглэжээ. Эцгийн талын ясан төрлийн холбоо нь МНТ-д Алунгуа эхийн таван хөвүүнээс эхлэн удмын угсаа залгамжийг ялган, удмын овгуудтай болсныг тэмдэглэсэнтэй дүйж буй билээ.

Ийнхүү хүннүгийн төрийн зохион байгууллын суурь болсон эртний бүл,



түүнээс үүссэн ураг болон овгийн байгуулал байх бөгөөд язгууртнуудын угсаа залгамжлалаар дамжин төр, төрт ёс бий болж, аж ахуйгаа дагаж үүссэн хүрээний хэлбэр нь нийгмийн зохион байгууллын жижиг нэгж болж байна. Тиймд төв азийн тал нутгийн нүүдэлчдийн тухайн газар оронд амьдарч буй ард түмний нүүдэллэн амьдрах газар нутгийн хүрээгээр захиргааны нэгжид хуваарилсан “газар- нутаг төвт” нийгэм болно.

МАН-гаа дагаж нүүллэдэг ард түмний хувьд мал болон бэлчих газар нутаг хоёр шууд хамааралтай байх бөгөөд энэ нь айл өрхийн тоо газар нутгийн хэмжээнд шууд хамааралтай гэсэн үг юм. Бэлчээр нутгаар хуваарилагдана, зааглагдана гэдэг нь тухайн газар нутагт амьдран буй айл өрхийн нэгдэл нь бөөнөөрөө цаг уурын нөхцөлөө дагаж нүүдэллэх тектоник хөдөлгөөнд орохоос бусдаар дан ганцаар тусгаарлагдах, эсвэл энд тэндээс хэсэг бусад хүн амаар нь таслан хуваах буюу хүчээр нэгтгэх боломжгүй юм. Үүнд нийтлэг нэг газар нутгийн хувьд тэр чигтээ өндөрлөг тэгш тал учир нүүдэлчид хоорондоо дайтаж, дотроо хөдөлгөөнд ороход үндсэн нийгмийн бүтэц зохион байгуулалт, түүний хэлбэр, үүрэгт бараг өөрчлөлт орохгүй тул тал нутгийн нүүдэлчид олон мянган жилийн соёлоо гүн бат бөх хадгалсаар ирсэн нь ч үүнтэй холбоотой гэж үзэж болно.

Тиймээс Хүннүгийн цэрэг захиргааны аравтын тогтолцоо нь эртний аймгуудын холбооны үед бүрэн төрхөөрөө зохион байгуулалтад орсон байсан бөгөөд эртний эхийн эрхт ёсны бүлийн нэгдлийн овгийн байгуулалд шилжих үйл явцтай зэрэгцээд бүрэлдсэн гэж үзэж болохоор байна. Уг аравтын нэгдэл нь бүлийн доторх хүрээний өрхүүд нэг нутагт айл саахалтаар нүүдэллэн амьдрах нүүдэлчин өрхүүдээс бүрдсэн газар-нутагт суурилсан органик нэгдэл байхын зэрэгцээ цэргийн зохион байгуулалт ч мөн энэ үед үүссэн гэж дүгнэх боломжтой болно.

*Зарлиг ёсны тухайд асуудлыг шинжлэх нь:* Модунь шаньюйн дуут сумны домог бол тал нутгийн нүүдэлчдийг нэгэн тэнгэрийн дор нэгтгэсэн, тэнгэрийн цаазад захирагдахыг, тэнгэрт үнэнч байхын утгыг шингээсэн юм. Төр болоод төрт ёсыг тунхаглаад, хаан болоод төрийн түшээд нь төрт ёсыг эрхэмлэн дээдэлж, түүнийг нэгэн сэтгэлээр даган мөрдөх төрт ёсны зарчмыг тунхагласан тунхгийн шинжтэй байдаг. Дуут сум нь шаньюйн зарлиг, хараа, итгэл, улсын хууль, тэнгэрийн зарлигийн илэрхийлэл болно. Модунь шаньюйн цэргээ бэлтгэж, дуут сум тавьсан зүгт даган сум тавихыг даалган, бага багаар харвах зүйлийнхээ үнэ цэнийг ахиулж буй үйлдэл нь итгэл болоод зарчмыг бэхжүүлэх арга бөгөөд уг зарчим нь ёсыг дагах, цаазыг биелүүлэхтэй утга нэг. Харин эхнэрээ өгсөн, эцгийгээ хөнөөсөн домгийг үнэн түүх хэмээхэд үнэний хувь багатай хэмээн судлаачид эргэлздэг. Н.Н.Крадин “Модэ эцгийнхээ амийг хөнөөж буй баримт үнэний хувьтай байх нь юу л бол .... бодит түүх гэхээс илүү ардын аман зохиол гэвэл зохих мэт” (Крадин 2012, 56) гэж тэмдэглэжээ. Уг домгийг үйл явдал талаас үнэн худал, харгис гэж өнөөдрийн өнцгөөс шүүн хэлэлцэх нь шударга бус агаад үнэнийг яг таг тогтоох боломжгүй юм. “Хятад төвт” үзлийн “бүдүүлэг”-үүд гэх ойлголтоороо нэмж хачирласан байх магадлал өндөр. Харин хүннүчүүдийн дундах ярианаас эсвэл өөрсдийнх нь хууч яриа, домгоос сийрүүлсэн гэж үзээд, нүүдэлчдийн баатарлаг домгийн сэтгэлгээний үүднээс тайлбарлавал зохино. Юутай ч Модунь шаньюйн домгийг тал нутгийн угсаатнуудыг нэгэн тугийн дор нэгтгэж, нэгдсэн хууль цаазын хүрээнд эзэнт

гүрний төрт ёсыг тунхаглаж, түүнийг даган мөрдөх, ёсчлон дагах зарлиг ёсны баримт, түүхэн үйлийн баталгаа гэж хэлж болох билээ.

*Төрийн бэлгэдлийн тухайд:* Хүннүгийн төрт ёсны илэрхийлэлд төрийн бэлгэдэл зүй ёсоор орох бөгөөд түүний уламжлалыг авч үзэх нь зүй юм. Судлаач Г.Сүхбаатар умард хүннүгийн шаньюйд МЭ 90 онд хаш тамга байсныг тэмдэглээд, мөн таван өнгийн туг, исэр, шүхэр зэрэг нь шаньюйн бэлэг тэмдэг байсан бөгөөд Чингис хаан ордондоо том цагаан туг хатгасан, луун толгойт чимэглэлтэй, алтан зүмбэртэй, улаан, шар торгон шүхэртэй байсныг сурвалжаар батлан ... “Хүннү монголын хооронд залгамж холбоо байсан гэж үзмээр байна” (Сүхбаатар 1980, 57) гэжээ. Төрийн бэлгэдэл нь төрт ёсны эрхэм дээд чанар, түүний үеийн үед тасралтгүй мандан бадарч байхыг илтгэх агаад угсаатны уламжлалыг цогцоор агуулж байдгаараа эрхэм дээд эрхэмлэлд ордог учиртай.

*Хэв хуулийн онцлогийг шинжлэх нь:* “Хүннү шастир”-т тэмдэглэснээр, хүннүд занчих, хорих, цаазаар авах гэсэн гурван төрлийн шийтгэл байх агаад “Тэдний хуулиар [хуйнаас нь] нэг чи (尺 Chi: 30.48 см) илүү сугалсан хүн үхэх ялтай” (СыМа Цянь 2014, 48) гэснийг орчуулагч тайлбарлахдаа “Хүннүчүүдийн дунд овгийн болон нийгмийн харилцааны эв нэгдэл нэгэнт тогтсон байсан, энэ зарчмыг зөрчигсөд үхэх ялтай байсныг илтгэж байгаа юм” гэжээ. Ийм зарчим хожмын монголчуудад ч байсныг Пано Карпини тэмдэглэлдээ “Тэдний хооронд аман хэрүүл гэж үгүй, хэзээ ч зодолддоггүй... Бие биенээ жигшиж зэвүүцэхгүй” (Пано Карпини 2006, 25) гэснээс харж болно. Мөн “..үүний гол утга нь хүнд заналхийлсэн бол цаазаар авахуулах ялтай байсан гэж ойлгож болно” (Дэлгэржаргал ба Батсайхан 2017, 173) хэмээн дүгнэжээ.

Мөн хулгай хийсэн хүнийг гэр бүлтэй нь холбоотой шийтгэх шийтгэлтэй байж. “Хулгайн хэрэгт ялагдсан хүний гэр бүлийг хураана” (СыМа Цянь 2014, 48) (坐盜者没入其傢 zuodaozhe mei ru chi jia ) (司马迁 无日期). Уг хуулийн утгаас харвал нэг гишүүний хариуцлага, ёс журам гэр бүлтэй нь хамаатай гэж үздэг байсан бололтой. Монголчуудын дунд хэлэгддэг айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг гэх зүйр үгийн уг санаа энд буйг тэмдэглэх нь зүйтэй. Пано Карпинийн тэмдэглэлд “Хулгайч гэж байдаггүй” (Пано Карпини 2006, 25) гэж тэмдэглэлсэн нь эртнээс байсан уг цаазтай холбоотойгоор тогтсон байх боломжтой юм. Үүнийг хулгай болон ёс бус үйлийн талаар “Эн тэргүүнд биеэ хайрлагтун, хоёрдугаарт, бүү завхайр, бүү хулгайл, бүү хуурамчаар гэрчил, хэн нэгнээс бүү урвагтун. Настныг болон ядуусыг хүндэлж яв” (Вернадский 2015, 74), (Сайшаал 2010, 401) хэмээн “Их засаг” хуулийн үзэл санааг тоймлосонтой утга дүйлгэж болохоор байна. Эдгээрээс харахад, бусдад хүндэтгэлгүй хандаж заналхийлэх, нийтийн эв нэгдэлд харшилсан ямар нэг зөрүү үйл, ёс бус хандлага зэрэг нь тал нутгийн “Ёс”-нд үл нийцэх хамгийн хүнд буюу цэргийн үүрэгтний тангараг зөрчсөнтэй дүйцэхүйц ялтай байсан энэхүү урвашгүй хатуу цаазыг МНТ-д гарч буй өрлөг жанждын тангарагтай дүйцүүлэн ойлгож болно.

Түүнчлэн “Хүннү шастир”-т “Хүннүчүүдийн хууль нь их энгийн бөгөөд хэрэгжүүлэхэд амар. Эзэн хаан болон албат нарын хоорондын харилцаа их энгийн учраас бүхэл бүтэн улсыг удирдах нь өөрийн биеийг удирдан залахтай төстэй юм” (СыМа Цянь 2014, 55) гэжээ. Эндээс үзвэл, хүн өөрөө хүний болоод байгалийн ёсонд

нийцсэн ёс суртахуунтай, түүнийгээ ухамсарладаг байх гэсэн зарчмын гаргалгаа харагдаж буй юм. Үүнийг Н.Лүндэндорж төрийн онолын үзэл санааны үүднээс “Төрийн эрх мэдлийг төрийн зүтгэлтний ёс суртахуунаар хязгаарлагддаг гэсэн ерөнхий үзэл санаа үйлчилж байв” (Лүндэндорж 2002, 21) хэмээн тайлбарлажээ. Хүннүгийн хэв хуульд буй хувь хүний өөрийн биеийг удирдан залах энгийн хууль нь хувь хүнд ёс суртахууны, ажил үүргийн маш өндөр хариуцлагыг үүрүүлж буй агаад энэ нийтлэг зарчим нь аравтын тогтолцоогоор дамжин хатуу хэрэгждэг хууль цаазын үндэс байж. Оросын судлаач В.И.Рязановский “Засаг” (“Ёс”) гэдэг үг нь хууль хориг, журам гэсэн үг мөн” гээд египт-арабын түүхч Макризийн “Дорно дахинд татаар нарын хүчин чадлыг илт харуулсан байлдан дагуулагч Чингис хаан Ван ханыг ялан дийлж, хамаг эрх мэдлийг гартаа аваад, зарим нэгэн гол ёс журам, зарим ял зэмлэлийг тогтоон тодорхойлоод, бүгдийг нь ном болгон бичээд, түүнийг “Ёс” буюу “Засаг” хэмээн нэрлэсэн байна. Их засаг хууль түүнийг залгамжлагчдын хувьд заалтыг нь өчүүхэн ч зөрчиж үл болох тийм хатуу чанга хууль болон хэвшжээ” (Рязановский 2002, 8, 11) гэснээс үзэхэд, хүннүгийн хэв хуулийн “ёс” нь “Их засаг” хуульд уламжлагдан хуульчлагдахын зэрэгцээ үндэстний сэтгэлгээний хувьд оюунлаг дээд хийсвэр утгатай болж иржээ.

Эдгээр хуулийн заалт болон тодорхойлолтуудад “ёс заншил, ёс журам, ёс суртахуун, заншлын хэм хэмжээ” зэрэг нь агуулгаараа цаад хүний хүний “ёс”-нд нийцэх итгэл үнэмшлээрээ эртний хүннүчүүдийн хууль цаазын гол хэмжүүр болж байсан бөгөөд суурь зарчмаараа, язгуур сэтгэлгээгээрээ Их Монгол Улсад уламжлагджээ.

“Дорно дахинд эзэн хааны эрх мэдэл, дур зоргыг хязгаарлах арга замыг дээд ёс суртахуун хэмээн үзэж, эзэн хаанаа тэнгэрийн хүү хэмээн өргөмжилж, тэнгэрийн хүү тэнгэрлэг ёс суртахуунтай байх ёстой бөгөөд тэрхүү ёс суртахууныг дагах нь тэнгэрт ивээгдэх гол шалтгаан хэмээн сургаж, эрх мэдэл, дур зоргоо хязгаарларлах механизмыг нь гадаад хүчин зүйлд бус өөрт нь суулган өгч, дур зоргыг нь хязгаарладаг далд нарийн аргыг хэрэглэж байсан бололтой. Тийм учраас хааны эрх мэдлийг хязгаарласан ямар нэг гэрээ хэлцэл, дүрэм журам, хууль зарлиг бараг байгаагүй гэж хэлж болно” (Амаржаргал 2015, 29) зэрэг тайлбаруудаас үзвэл “төр” гэх ойлголт нь язгуур утгаараа соёлын утгатай дүйж, төрт ёс нь заншлаас улбаатай ёс суртахуун дээр суурилсан, ёс журам нь хариуцлага, ёс суртахуунжсан, сахилга батажсан хэлбэртэй байна. Төрт ёсны үндэс нь байгалиас хүнд заяагдсан заяагдмал өгөгдөл чанарыг хамгаалах, түүнийг нь тэтгэж байдаг байгалийн жамд нийцсэн, цээрийн шинжтэй, ёс суртахуунжсан байсанд гол утга нь оршиж буй юм. Тиймээс түүнийг даган мөрдөх нь дээд хүмүүний чанар хэмээн үздэг байна. Өөрөөр хэлбэл, нийт угсаатны сүсэг бишрэл, итгэл үнэмшлийг “тэнгэрийн ариун ёс” болгон төрийн эрх мэдлийг угсаатны сэтгэлгээний язгуур чанарт нийцүүлэн хэрэгжүүлэхдээ ашиглаж чаджээ. Түүнчлэн нийтийг хамарсан ан ав, адууны соёл зэрэг нь тэдний цэргийн сургуулилт болдог байсан ба нийт нийгмийг хамран, амьдрах хэв маягаараа үүрэгжсэн цогц тогтолцоог бий болгож, уг тогтолцоогоор дамжуулан төрт ёсыг хэрэгжүүлдэг байж. Тиймд аравтын тогтолцоо нь “Тухайн нийгэмд амьдрах нөхцөл; Иргэн болох хэрэгсэл; Төр улсад хүчин зүтгэх, өөрийгөө харуулах зэвсэг байсан” (Алгаа 2012, 88) ба “Хүннү нарын хувьд “цэрэг” хийгээд

ард түмэн гэдэг нь нэг л ухагдахуун болсон байв” (Гумилёв 2000, 48).

Ийнхүү монголчууд Хүннү гүрний төр нийгмийн тогтолцоо, хэв хууль, төрийн бэлгэдэл, төрт ёсыг хойчийн “Сянби, Нирун, Жужан улсуудаар дамжуулан өвлөн авсан” (Сүхбаатар 1980, 168), (Шагдаржав 2008, 61) бөгөөд уг төрт ёсны уламжлал “газар нутаг төвт” тогтолцоо нь газар-нутаг хэмээх өөрчлөгдөшгүй байгалийн тогтоц, түүний үндсэн нөхцөл байдалд нөхцөлдөж бий болсон төв азийн тал нутгийн нүүдэлч угсаатны сэтгэлгээний язгуур чанарт суурилж боловсруулсан, удирдлагын босоо тэнхлэгтэй, газар нутгийн хэвтээ тэнхлэгтэй, “ёс төржсөн” цогц агуулга бүхий бүхэллэг шинжтэй, нэгдмэл тогтолцоо байв. Хүннү, түүнээс өмнө төв азийн тал нутагт мөн л нүүдэлчид л амьдран байсан бөгөөд уг газар нутаг бүтнээрээ Хүннү гүрний харьяанд байж, бүтнээрээ Их Монгол Улсад өвлөгдөөд зогсохгүй түүнийг тэлсэн үзэл баримтлал, төрт ёсны уламжлал нь газар нутаг, түүний бүс нутгийн онцлогт шууд хамааралтай байгаа билээ.

### 3. Соёл-Ёс заншлын тухайд

Дэлхийн соёлын түүхнээ тухайн газар байсан, байгаа том соёлуудыг төрт улсаар нь нэрлэж, төр байгуулсан түүхээр нь оршин тогтносон цаг хугацааг тогтоож, тухайн улсын хамарч байсан газар нутгаар нь соёлын тархалтыг тогтоон нэрийддэг. Гарваль зүйн талаасаа, тухайн газар нутагт үүсэн бүрэлдсэн цаг хугацаанд холбогдуулан цуваа цагийн үүднээс угсаатны сэтгэлгээний түүхийг авч үзэх нь сэтгэлгээний жимийг алдалгүй барьж авах аргачлал юм. Энэ утгаараа соёл бол тухайн газар нутгийн онцлогоор нөхцөлдөж бүрэлдсэн хүний сэтгэлгээний хэлбэржил, цар хүрээ, илэрхийлэл бөгөөд хэл, бичиг үсэг, зан суртахуун, ахуйн зүйлс, урлагийн зүйлс, нийтлэг сүсэг бишрэл, зан заншлын үйл, аливаад хандах хандлагаар илэрдэг байна.

Эрдэмтэн Б.Сумъяа “...байгалийн гаралтай ухамсаргүй шунал, тачаал, сөрөг үйлдлийг хянаж, хязгаарлаж, оюун ухааныг зөв зүгт залж чиглүүлж байдаг тэр зүйлийг бид зөвхөн homo sapiens-ийн чанар буюу хүмүүн зүйл гэж нэрлэж байгаа юм ... хүмүүн зүйл нь соёлын уг язгуур” (Сумъяа 2001, 14, 25) гээд, цааш нь соёлын уг язгуурт мэдлэг ухаан, зан суртахуун, гоо сайхны зохист эрмэлзлэл зэргийг багтаан авч үзжээ. Эдгээр чанаруудыг нийтдээ нэг бүхэл юм гэж үзвэл, хүний ахуйн үйлээс эхлээд оюуны хийсвэр үйл хүртэл нэгэн жим татаад, түүнд нэг ижил талаараа нийлж буй шинжийг нь авч үзэх, тодруулах, зүй тогтлоор нь байрлуулсан тасралтгүй үргэлжлэх заншлын гинжин хэлхээ болно. Үүнд тулгуурлавал, нүүдлийн соёлын язгуур нь нүүдэлчид, мал болоод мал маллагаатай холбоотой үүссэн арга ухаан, хүн-мал-байгаль гурвын хоорондын ойлголцлын түлхүүрүүд, түүний илэрлүүд болох сүсэг бишрэл, түүнтэй холбоотой ёс заншил, ёслолын үйл, баяр наадмын ёслол зэрэг болохоос гадна, түүнийг үүсгэгч анхдагч суурь нөхцөл болох газар нутаг, бүс нутаг, газар зүйн орчин болно.

Тал нутгийн нүүдэлчдийн хувьд тал нутаг, түүний цаг уурын онцлог нь тэднийг байгалийн араншинг дагахад хүргэж, хүн өөрөө мод, чулуу, өвс ургамлын нэгэн адил байгалийн нэг хэсэг, байгалийн нэг эд эс хэмээн сэтгэхэд сургасан агаад ер тэдний хувьд хүн байгалийг эзэмших, өөрийнхөө төлөө өөрчлөх бус түүнд зохицон, түүний эд эсүүдтэй адил тэгш эрхтэйгээр орших нь жам ёс аж. Уг жам

ёсны ойлголт нь тэдний соёлын үндэс, ёс заншил, сэтгэлгээний ялгаатай тал юм. Уг ёс заншил гэдэгт ахуйн бодит соёлоос оюуны хийсвэр заншмал сэтгэхүй хүртэл хамаарна.

Хүннүчүүд нар сарны шүтлэгтэй байсан нь “Шаньюй өглөөд өргөөнөөсөө гарч мандах наранд мөргөл үйлдэнэ. Оройд саранд мөргөнө. Тэрбээр суухдаа хойш харан суух бөгөөд түүний зүүн тал нь хүндтэйд тооцогдоно” (СыМа Цянь 2014, 48), “Хүннү, Жужан нар зүүн зүгийг эрхэмлэдэг байжээ” (Сүхбаатар 1980, 136) гэснээс тодорхой. Түүнчлэн “Жил [болгоны] нэгдүгээр сард бүх түшмэд шаньюйгийн өргөөнд бага хуралдайд цугларан тахилга хийж өргөл барьц өргөнө. Тавдугаар сард Лунчэн (笼城)-д их хуралдайд цугларан өвөг дээдэс, тэнгэр газрыг тахих бөгөөд хүмүүсийн сүнс болон газар тэнгэрийн савдагт мөн тайлга өргөнө. ...Шаньюй өглөөд өргөөнөө гарч мандах наранд мөргөл үйлдэнэ. Оройд саранд мөргөнө” (Сүхбаатар 1980, 48) гэснээс үзэхэд бөө мөргөлийн шүтлэг, түүний тахилга, тайлга хийх үйл төрийн үйл хэрэг болоод, ард түмний аж ахуй амьдралд холбогдсон агуулгаараа нэлээд боловсронгуй түвшинд хүрсэн байжээ. Нар, сарыг шүтэх ёс нь төрийн далбаа, сүлд зэрэгт дүрслэлээрээ уламжлагдсанаас гадна сарны гарцаар бэлгэдэн үйл үйлддэг ертөнцийн хөдөлгөөнт чанарт холбогдох ёсон байж. Мөн “Байдэн (白登 Bai deng) ууланд Хан улсын цэргүүдийг бүсэлсэн дөрвөн зуун мянган морьтны “Баруун жигүүрийн морьтон хүннү нар бүгд цагаан [морьтой] байсан бол зүүн талынхан халиун халзан морьтой, умард талынхан хар морьтой, урд талынхан хүрэн морьтой” (СыМа Цянь 2014, 49) гэснээс тэдний хувьд өнгөний бэлгэдэл нь байгалийн өнгө болон малын зүстэй холбоотой төлөвшжээ. Эдгээр нь өнөөгийн монголчуудын хувьд ч хэвээр байгаа чухал бэлгэдэлт ёсон билээ.

Хүннүгийн соёлын талаар тодруулахад, монгол нутгаас олдож буй оршуулгууд чухал ач холбогдолтой. Сурвалжийн мэдээнээс үзэхэд, хүнийг оршуулах ёс заншил нь хүнийг нөгөө ертөнцөд үдэх чухал үйл байхаас гадна, дайны талбарт алагдсан хүний шарилыг авчирсан хүн тэр хүний хөрөнгийг авдаг байснаас үзэхэд маш хүндэтгэлтэй ханддаг байсан нь эх нутагт оршуулах, мөн хүнийг оршуулах ёсонд хаана оршуулах газрын асуудал чухал байсантай холбоотой гэж үзэж болох бөгөөд өнөөгийн монголчуудад ч хэвээр буй хүн оршуулах газрыг чухалчлан үздэг нарийн ёсон билээ. Дээл хувцас, эдлэл хэрэглэл, ойрын туслахууд, морь мал ч дагалдуулан оршуулдаг байсан, “Дагуул булшин дахь оршуулга нь урдаас хойш насны эрэмбээр явсаар хамгийн хойд захад насаар хамгийн ахмадыг (40 хүртэлх насных) нь оршуулсан” (Эрдэнэбаатар 2021, 38) зэргээс харахад маш нарийн дэгтэй байхаас гадна тэдний хүний ертөнцийн талаарх төсөөллийн дүр зургийг тодруулж болохуйц нарийн бүтэц байх аж. Плано Карпинийн тэмдэглэлд “Амьд ахуйдаа хэрэглэж байсан олон гэрийн нэгний голд суулгаж өмнө нь тогоо дүүрэн махтай, аяга дүүрэн айрагтай ширээ засаж оршуулна. Хойд төрөлдөө амьдрахад гэртэй, саах гүүтэй, өсгөн үржүүлэх, унаж эдлэх агт морьтой байлгахаар унагатай гүү, эмээл хазаартай морь тавихаас гадна, нэг адууг нядалж идээд, идсэн адууны арьсанд өвс чихнэ. Энэхүү чихмэлийг талийгаачийн дээр хоёроос дөрвөн модон саваан дээр өргөн байрлуулаад нутаглуулдаг ажээ...Хамгийн сайн зарцыг талийгаачийн доор хэвтүүлнэ. Тэр нь тэнд удаан байж амь тавьж эхэлмэгц түр зуур дээш татан гаргаж амьсгаа авахуулаад эргээд хэвтүүлдэг, иймэрхүү маягаар

гурван удаа давтана. Хэрэв амьд үлдвэл эрх чөлөөтэй болж дуртай юмыг хийж амьдарна, тэр ч бүү хэл, талийгаачийн хамаатан саднуудын хүрээнд болон гэрт байх хүмүүсээс хамгийн нэр хүндтэй нь болдог ажээ” (Плано Карпини 2006, 26) гэснээс үзвэл, хүннүчүүдийн оршуулгын ёслолын гол агуулга, хэлбэрээрээ уламжлагдаж, ойрын туслахууд зэрэг амьд хүмүүсийг шууд оршуулах зэрэг зан үйл нь өөрчлөгджээ. Түүнчлэн “Хүннү нарын оршуулгын барилга, ерөнхий зан үйл нь ер түрэгчүүд болон Орхоны түрэгийнхээс эрс ялгаатай бөгөөд XIII зууны үеийн монголчуудынхтай адил байна” (Сүхбаатар 1980, 136) гээд зарим зан үйл нь саяхныг хүртэл халх монголчуудад байсан гэж тэмдэглэжээ.

Хүннүчүүд нум сум харваж, морь уралдуулж (Сүхбаатар 1980, 137), бөх барилдаж (Монгол Улсын их сургууль 2003, 243) нааддаг эрийн гурван наадамтай байсан нь өнөөгийн монголчуудын соёлын шууд улбаа юм. Эрийн гурван наадам нь эртний нүүдэлчдийн цэргийн эрдмээс улбаатай, тал нутгийн нүүдэлчдийн ёс жаяг, ёс заншил, ёс суртахуун, ёс хүндлэл, хайр хүндэтгэл, сурган хүмүүжүүлэх ухаан зэргийг цогцоор агуулсан соёлын өв билээ. Монголчуудын мал маллагааны арга ухаан морин соёлтой салшгүй холбоотой, язгуур утгаар нь авч үзвэл, хүннүгээс өмнө мал гаршуулах болон морин соёл зэрэг үүсэн бий болсон байх учиртайн дээр МАА-н соёл бүрэн төлөвшихтэй зэрэгцэн амьдарлынх нь явцад хөгжиж, сонгодог үндэсний баяр наадам болсон гэж үзэх нь зүйтэй.

Хувцас хэрэглэлийн хувьд Ноён уулын язгууртны булшнаас гарсан олдвор болон түүхийн сурвалжид үндэслэн хүннү, сянби, жужан, хятан нар нь ижилхэн “нар баруун, зүүн тийш зөрдөг энгэртэй дээл, ээтэн хоншоор бүхий сөөхий маягийн гутал, агсарган бүстэй байсан” (Дэлгэржаргал ба Батсайхан 2017, 230), (Соёл, урлаг судлалын хүрээлэн 1999, 204), (Сүхбаатар 1980, 168) гэж баталжээ.

Ийнхүү төв азийн эртний нүүдэлчдийн тал нутгийн угсаатны биеэр болоод сэтгэл зүрх, оюун санаа, сэтгэлгээгээрээ тээж ирсэн тэр бодит болон хийсвэр хэлбэр бүхий агуулга нь байгальтай нөхцөлдөж бүрэлдсэн соёлын үндсэн язгуур чанарыг илэрхийлж буй юм. Хийсвэр агуулгаараа ёс заншил, сүсэг бишрэл, байгальд хандах хандлага зэрэг нь оюуны соёлыг бүрэлдүүлэгч, эдгээрийн бодит дүрслэл, үйлдэл нь соёлын бодит ахуй болох бөгөөд төрт ёсонд эдгээрийн зохицлыг заншлын хэв хуульд хамруулан үздэг. Энэ нь төв азид хүн амьдарч эхэлсэн цагаас хүний биологийн хүчин зүйлтэй нэгдмэл байдлаар бүрэлдсэн угсаатны сэтгэлгээний урсгал нь өөрчлөгдөшгүй чанар агаад ёс заншлын хэлхээгээр тайлбарлагдах билээ. Түүнчлэн хэв хуулийн ёс суртахуунлаг чанар нь төрт ёсны үндсэн баримтлах үзэл санаа нь болохын зэрэгцээ соёлын ёс суртахуунжсан хэлбэртэй нэг тэнхлэг дээр огтлолцож, ёс заншлыг дээдлэх, даган мөрдөх үйлээр илэрч байна. Энэ агуулгаараа соёл нь “төр” гэж хэлж болно. Нэгэнт хүннүгийн соёл, төрт ёсны тогтолцоо нь дараагийн улсуудаар дамжаад өнөөгийн монголчуудад уламжлагдаж, язгуур шинжээр нь дамжин тэдний шүтлэг бишрэл, ёс заншил, хүний язгуур өгөгдөлд суурилсан хүний эрхийн талаарх жам ёсны ойлголтыг агуулсан сэтгэлгээний урсгал нь уламжлагдаад ирчихсэн, тэр нь соёлын бүх хэлбэрээр илэрч байгаа нь монголчууд хүннүтэй угсаатны сэтгэлгээний язгуураараа холбоотой бидний шууд дээд өвөг гэж үзэж болох нотолгоо мөн.

#### **4. Иргэншил-Ёс суртахуунт хэм хэмжээний тухайд**

Сонгодог МАА-н хүрээнд үүссэн соёлын хам хүрээ бол бидний сонгодог иргэншлийн хүрээ. Хүннүд мал нь хувийн өмч байсан нь багтай. Мал хувийн өмч болсон нь өмнөх неолитын үеийн овог, аймгийн үед тогтсон гэвэл түүнээс өмнө мал гаршуулах нь хүмүүс өөрсдөө хувь хувьдаа гаршуулж, өөриймшүүлсэн, эсвэл нэг овог бүлээр хамтран гаршуулсан байж болно. Амьтан гаршуулах үйл явц нь одоогоос 14 мянган жилийн тэртээгээс эхэлж, шинэ чулуун зэвсгийн үед төв азид малыг бойжуулснаар мал аж ахуйн суурь тавигджээ. Энд амьтан гаршуулж, улмаар малыг бойжуулах үйл явц нь өөрөө төв азийн ард түмний байгальд амьдрах, түүнтэй харьцах уламжлалт арга ухааныг бий болгож, соёл иргэншлийн эхийг тавьсан нь нүүдэлчдийн тал нутагт иргэнших язгуур шинж бүрэлдэн тогтох үндэс суурь болж буй юм.

Иргэншил нь соёлын мөн чанар гэж үзээд бүс нутгаар тодорхойлогдох боломжтой гэж иргэншил судлаачид үздэг. Харин соёлын тодорхой түвшний хэлбэршил нь иргэншил хэмээн тодорхойлдог бөгөөд “Иргэншил бол соёлын орон зай, хэв маяг, гоц үзэгдлийн нийлэмж юм” (Энхтүвшин 2021, 157) гэсэн нь соёл иргэншил хоёр нь нэгдмэл болохыг хэлжээ. Тэгэхээр соёл нь иргэншлээ, иргэншил нь соёлоо тодорхойлж буй бөгөөд дээр өгүүлсэнчлэн соёл төр хоёрын уулзвар дээр иргэншил үүсэж байна.

Тэхээр “Хүннүгийн хүн амын тоо 1 сая 200 мянга орчим, ...малын тоо дунджаар 10 сая 300 мянга орчим байсан” (Монгол Улсын их сургууль 2003, 227) уудам газар нутагт хүн, мал чөлөөтэй бэлчих, ан агнуур, цэргийн сургуулилт зэрэгт гойд тохиромжтой байсан нь тал нутгийн нүүдлийн иргэншилд л байх хөдөлгөөнт чанар бөгөөд тэдний иргэншил дэх дотоод гол язгуур нөхцөл, хөдөлгөгч хүч нь болж буй юм. Уг уян хатан, орон зайн тавиу чанар нь нийгмийг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийг нэг нэгэнд нь уусган харилцан хамааралд нь барих гол холбоос нь болж байна. Энэхүү нийгмийн тогтолцооны хувьд соёл нь тухайн угсаатны сэтгэлгээний талыг бүрдүүлдэг бол иргэншил нь төр, соёл хоёр буюу ёс-ёс суртахууныг хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээнд холбосон нийгмийн харилцааны агуулга бүхий тогтолцоо болж байна. Түүнчлэн хүннүгийн соёл-иргэншилд ард түмний сэтгэлгээн дэх төр нь “ёс”-ыг хэрэгжүүлэгч, түүгээрээ хүмүүний дээд эрхийг хамгаалагчийн үүрэгтэй хэмээн дүгнэж болно. Тэгэхээр төр, соёл, иргэншил гурав нь “ёс”-оор холболдож, энэ гурвын дээр бүрэн эрх нь “тэнгэрийн ёс”-ыг дагагч хаанд байгаа боловч аймгуудын язгууртнудаас бүрдсэн хуралдайтай байсан нь шаньюйн шийдвэрт нөлөөтэй байсан байх бүрэн боломжтой.

Ийнхүү иргэншил нь мөн чанараараа хүн төрөлхтний материаллаг болоод оюунлаг соёлын нийлбэр цогц байх агаад хүннүгийн соёл иргэншил нь тэдний өөрсдийнх нь “сэтгэлгээний ёс”-нд суурилсан оршихуй бүхий төр-нийгэм-соёл-иргэншлийн цогц нийлэмж бүхий тогтолцоо байжээ.

#### **5. Тэнгэрчлэл (Бира 2011, 106) - Оюунлаг сэтгэлгээний тухайд**

Ер эртний нүүдэлчдийн сэтгэлгээнд “тэнгэр”-ийн тухай ойлголт сүсэг бишрэлтэй нь холбогдож үүссэн зайлшгүй өгөгдөл байх агаад үүнийг ойлгохдоо нүүдэлчин угсаатны сэтгэлгээний гарлын мөн чанарт уялдуулж авч үзэх нь зүй

юм. Эртний нүүдэлчин монголчуудын хувьд бөө мөргөлийн тэнгэрийг шүтдэг байсан нь өнөөгийн монголчуудад уламжлагдан ирсэн билээ. Тэнгэр шүтлэг нь тал нутагт хүн үүссэн цагаас эхлэн үүсэж, нүүдэл соёл, монголчуудын төрт ёсны түүхтэй зэрэгцэн хөгжсөөр оюуны хийсвэр дээд түвшинд хүрсэн нь тал нутгийн нүүдэлчдийн байгаль эх дэлхий, дээд эцэг тэнгэрийн үзэл баримтлалаар орчлон ертөнцийг бүхэллэг цул оршихуйд ойлгож, бүхий л ертөнцийг үүсгэгч нь “Тэнгэр” хэмээн сэтгэгдээр илэрдэг. Энэхүү тэнгэрчлэлийн төрт ёсны эрхэм дээд чанарыг илэрхийлэх сэтгэлгээний дээд хэлбэр нь эртний нүүдэлчдээс эхлэн хаад язгууртнаа “тэнгэр” гаралтай хэмээн үздэг үзлээр илэрч иржээ. Сурвалж бичгүүдэд тэмдэглэсэнээр, Хан улсын бичигт: Chenli gutu буюу тэнгэрийн хүү (蒙犁孤塗單于), ”Хүннү шастир”-т: Тэнгэрт тэтгэгдсэн (天所立), Тэнгэрийн ивээлээр (以天之福), Тэнгэр газраас төрж нар сараар ивээгдсэн” (СыМа Цянь 2014, 56) гэх зэргээр шаньюйг “Тэнгэр заяат” хэмээн өргөмжилж байснаас тодорхой. МНТ-д Чингис хааныг “Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно, Тэнгэр газар элдэж, Тэмүүжинг улсын эзэн болтугай, Тээж хүргэж явна гэж мөөрнө” (МНТ 2009, 23, 59) гэх зэрэг нь хаадын язгуурын тэнгэр гарлын талаарх баримтлалаа хүннүгээс шууд уламжлан авсан язгуур сэтгэлгээний уламжлал юм. Түүнчлэн шаньюйн нар, сарны мөргөл, тэнгэрийн тахилга тайлгын ёслолыг нийт ард түмнээрээ үйлддэг (СыМа Цянь 2014, 48) байснаас үзэхэд тэнгэр шүтлэг нь нэлээд боловсронгуй түвшинд хүрч, “Төрийн шашны шинжийг олж байсан” (Сүхбаатар 1980, 141). Эрдэмтэн Ч. Жүгдэр “Хүннүчүүд шаньюйг “тэнгэрийн хөвгүүн” хэмээн өргөмжилж, албан бичигт “Тэнгэрийн хүчинд суусан их шаньюй” гэж бичих болсон, хоёр улсын гэрээг батлахад бөө мөргөлийн зан үйлийг үйлдэх болсон, энэ бүхэн нь уг шашныг төрийн хэрэгт хэрэглэх болсны гэрч даруй мөн болой...Тэнгэризм бол хүннүгийн бөөгийн шашны ертөнцийг үзэх хөгжингүй үзэл мөн” (Жүгдэр 1987, 36) хэмээн баталж бичжээ. Тэрээр “... Хүннү нарт ангит нийгэм үүссэний улмаас шаньюйгийн ганцаар ноёрхох, засгийн үзэл суртлыг зөвтгөх үндэс нь бөөгийн шашны ганц бурханизм (монотеизм) болсон байдаг” (Жүгдэр 1987, 36) гэж үзсэн нь бөөгийн тэнгэр нь шашны хувьд бурханчилсан дүрийн хэлбэр ч гэлээ төрийн эрхэм чанарын хувьд тэр нь “төрт ёс”-ны ёс суртахуунлаг зарчмын утгыг мөн илэрхийлж байжээ. Уг зарчим нь “тэнгэр ёс”-ны нэрээр ойлгогдож байсан агаад Хүннү гүрний үед ийнхүү угсаатны язгуур оюунлаг сэтгэлгээний хувьд сонгодог хэлбэрээ олчихсон байв.

Хүннүгийн шаньюй Хань улсын хаанд бичсэн захиандаа “Тэнгэрийн ивээлээр, миний дайчин баатруудын хүчээр, хүлэг морьдын шандасын хүчээр... нум агсагч улсууд бүгд нэгэн тугийн дор нэгдэж, умард нутагт тайван байдал тогтов” (СыМа Цянь 2014, 52) гэсэн нь хүннүгийн удирдлагад тэнгэр ёсны шаталсан зарчим хэрэгждэг байсны нотолгоо юм. Харин эзэн хаанаа тэнгэрээс гаралтай хэмээн өргөмжилж, бурханчилдаг байсан нь төрөө хүндлэх хүндлэл, бэлгэдлийн агуулгагай бөгөөд эзэн шаньюй бол тэдний хувьд төрийг, төрийн тэнгэрийг төлөөлдөг, төрт ёсны бэлгэдэл болж байж.

Их Монгол Улсын үед бүрэн төгөлдөржиж, бүх ертөнцийг эрхшээх агуулга бүхий битүү тойрог хэлбэрийн оюунлаг сэтгэлгээний тогтолцоо болж ирсэн нь Чингис хааны сургаал, түшмэдийн тангараг, Их засаг хууль зэрэгт тодорхой тусчээ.



### Чингис хаан:

Эрэмгий сайнаар эзэн эс боллоо, би  
Эцгийн хайраар эзэн боллоо, би  
Эцэг тэнгэрийн ачаар эсрэг дайснаа дарлаа, би  
Хамтрагч сайнаар хаан эс боллоо, би  
Хан тэнгэр эцгийн хайраар эзэн боллоо, би  
Хан тэнгэр эцгийн өршөөлөөр харь дайсныг дарлаа, би хэмээн дээд тэнгэртээ шүтэн, өөрийгөө түүний нэрийн өмнөөс хаан суусан, түүний зарлигийг биелүүлэх үүрэгтэй хэмээн тооцож байсан бол,

Тэнгэрт өршөөгдөж газарт ивээгдэж  
Энэ шийдвэрээ эвдэхгүй  
Эв зангиагаа таслахгүй  
Эх захаа алдахгүй  
Эгнэгт журамтай бай хэмээн доод тушаалын түмэнд хандаж доош чиглэсэн сургаал айлдаж байна. Харин түүний жанжид:

“Харвах сумны халхавч болж  
Хангинах зэвийн бамбай болж  
Итгэлт эзэн чиний идэт биед  
Ирт мэс бүү хүргэе” (Борохул)  
...алтан жолоог чинь алдалгүй дагаж  
Хандсан зүгт чинь хагацалгүй явъя” (Боорчи)  
“...Харь дайсныг довтлох цагт  
Хаан эзэн Чингис чамд  
Хашир миний боломжит үг

Хааяа боловч тус болно” (Чуу мэргэн) (МНТ 2009, 78) гэх мэтээр дээд хаанд тангараглаж байна. Түүнчлэн хааны тамганы бичээст “Мөнх тэнгэрийн хүчинд (дор) Их Монгол Улсын Далайн хааны зарлиг булха иргэнд (дор) хүрвээс биширтүгэй, айтугай” (Сайшаал 2010, 397) хэмээх тэнгэрийн ёсыг дагах ард түмнийг ёсонд дагуулах баримтлалаар илэрч байв. Энэчлэн захирагдах ёсны эрэмбээр босоо чиглэлтэй “тэнгэрийн ёс” нь мөн давхцах бөгөөд “тэнгэрийн ёс”-ны битүү тойрог хэлбэрийн бүтэц үүсгэж байна. Энэчлэн эртний монголчуудын тэнгэр шүтлэгийн төрт ёсон дахь ойлголт нь эзэнт гүрний үед хийсвэр сэтгэлгээний тэнгэрлэг дээд түвшинд хүрч хэлбэржжээ. Ийнхүү “тэнгэрийн ёс” нь байгалийн жамыг даган мөрдөх дээд ёс суртахуун болон “хуульчлагджээ”.

### Хэлэлцүүлэг

Ийнхүү газар эх буюу биеийг үүсгэгч материйн ертөнц, тэнгэр буюу оюуныг үүсгэгч хийсвэр ертөнц аж. Дунд тивд буюу газар тэнгэрийн хооронд амьдрах бид хоёр тив, хоёр ертөнцийг холбосон тал нутгийн сэтгэлгээний “бодитчилол”-ыг үүсгэсэн нь бөөгийн тэнгэрийн ёсыг бүх хүн төрөлхтөний сэтгэлгээний эрх чөлөөнд нийцүүлэн ёсчлон дагах зарчим болно.

“Тэнгэрчлэл”-ийн улс төрийн агуулгаараа шашин бус, түүний хүний сэтгэлгээний байгалийн жам ёсонд нийцүүлэн хүний эрхийг дээдэлдэг зарчим нь эзэнт гүрний үед бүх дэлхийн шашин шүтлэгийг эн тэнцүү хүндэтгэн үзэж, эрх

тэгш оршоож байсанд оршино. Уг зарчим нь тэнгэрчлэлийн оюунлаг сэтгэлгээний илрэл бөгөөд үүнийг “Мөнх тэнгэр бол зөвхөн өөрөө “үнэмлэхүйн дээд”, “үнэн болж биелсэн” оюун санааны үзэгдэл төдийгүй, “үнэнийг үнэн болгон заяасан” буюу “үнэний үүсгэл”, “оюуны урсгал” болж явдаг чанараараа оюун санааны аливаа эрх-тогтоолын мөнхийн шүүгч болж байдаг” (Дулам 2018, 302). Уг зарчим нь тэнгэрчлэлийн босоо тэнхлэгийн оюунлаг сэтгэлгээний дээд хэлбэр бөгөөд төрийн бодлого дахь хэрэгжилтээр илэрч буй юм.

Тэнгэр, газрын нэгдэл нь эрт үедээ бүхнийг үүсгэгч бөгөөд гагцхүү “ёс”-г тогтоогч байсан бол оюунлаг дээд урсгалдаа тэнгэр нь байгаль, ертөнцийн орчил хөдөлгөөн, түүнээс үүдэлтэй хувиршгүй мөнхийн оршихуйг төлөөлөгч болж байна. Ийнхүү газар үгүй бол тэнгэр үгүй агаад тэнгэр нь нүүдэлчдийн “газар-нутаг төвт” ахуйлаг сэтгэлгээнээс оюунлаг сэтгэлгээнд шилжсэн хэлбэр болно. Тэнгэр нь монголын тэнгэрчлэх сэтгэлгээнд цаг хугацаа, орон зайн хэмжүүрээс хальсан нийлэг бүхэллэг чанартай болжээ. Өөрөөр хэлбэл, тэнгэрийн шинжүүд нь нэгнээс нөгөөд аажим уусах тасралтгүй сэтгэлгээний хөдөлгөөнт урсгал болох ба шаталсан эрэмбэтэй, эхлэл төгсгөл, орой ёроол хоёр нь нийлдэг битүү хэлбэртэй цэвэр оюуны болон сэтгэлгээний урсгал юм.

### Дүгнэлт

Хүннүгийн нийгмийн байгууламж нь эцгийн талын ясан төрлөөр холбогдсон бүл доторх өрхүүдийн нэгдэл байх бөгөөд тэдгээр өрхүүд нь МАА-гаа дагасан газар-нутагт суурилсан нүүдлийн нийгмийн тогтолцоотой байна. Энэ нэгдэл нь газар нутгаар хувиарилагдсан, дотроосоо гадагшаа тэлдэг эв хамтын нэгдэл бүхий амьдрах хэв маягт суурилсан цэрэг-захиргааны аравтын тогтолцоо байсан бөгөөд бүх нийгмийг хамарсан төрт ёсыг хэрэгжүүлэгч сүлжээ байжээ. Уг тогтолцооны мөн чанар нь гагцхүү тухайн газар нутагт амьдрагч уугуул иргэдийн байгальд нөхцөлдөж буй болсон тал нутгийн нүүдлийн соёл, түүний сэтгэлгээний тал болох сүсэг бишрэлийг хүндлэх, заншлыг үл зөрчих “ёс”-ыг хууль цааз болгон төрийн ёсонд ашиглаж, “ёс”-ыг үүсгэгч нь “тэнгэр” бөгөөд “тэнгэрийн ёс” нь бүх ертөнцийн туйлын үнэн хэмээх оюун санааны итгэл үнэмшлийг бий болгосонд орших, төр-соёл-иргэншлийн цогц бүтэц бүхий тогтолцоо байв.

Түүнчлэн өнөөгийн монголчуудын тэнгэрчлэх сэтгэлгээний язгуур хэлбэр нь Хүннү гүрэн болон өмнөх хүннү аймгуудаас өмнөх аймгийн холбоодын үед бүрэлдсэн гэж үзэх нь зүйтэй байна. Хүннүчүүдийн язгуур сэтгэлгээг дараагийн төрт улсууд болон Монголын эзэнт гүрнээр дамжуулан өнөөгийн монголчууд бүрэн өвлөн авсан нь үнэн бөгөөд уг язгуур сэтгэлгээний мөн чанар, гарал үүслийг тодруулах нь уг сэтгэлгээний хүрээнд бүтээгдсэн уламжлалт урлаг соёлд онолын үүднээс тайлбар хийх дараагийн шатны судалгаанд ач холбогдолтой хэмээн найдаж буй юм. Ингэхийн учир нь монголчуудын дээд гоо зүйн ойлголт мөн л энэхүү ёсонд хамаатаж, энэхүү ёсоор хэмжигдэх, түүнээс ургуулан тайлбарлагдах учиртай билээ.

### Ашигласан материалын жагсаалт

- Алгаа, Пүрэвдорж. 2012. *XIII зууны монголчуудын амжилтын түлхүүр*. Улаанбаатар.
- Амаржаргал, Пэлжид. 2015. *Үндсэн хуулийн эрх зүй. Парламентын онол үзэл баримтлалын асуудал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Бира, Шагдар. 2011. *Монголын тэнгэрийн үзэл*. Улаанбаатар: Сод пресс ХХК.
- Вернадский Г.В. 2015. *Монголын эзэнт гүрэн*. Улаанбаатар: Монсудар.
- Гумилёв Л.Н. 2000. *Евразийн түүхээс*. Орч. Наран Д. Улаанбаатар: Наранбулаг принтинг.
- Дулам, Сэндэнжав. 2018. *Домог зүй бөө мөргөлийн судалгаа*. Улаанбаатар: Монгол Улсын их сургууль, Монгол судлалын хүрээлэн.
- Дэлгэржаргал, П., Батсайхан, З. 2017. *Хүннү*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Жүгдэр, Чимэд. 1987. *Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ. Эртнээс 14-р зуун хүртэл*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Крадин Н.Н. 2012. *Хүннү эзэнт гүрэн*. Орч. Ганбат Н. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Лүндэндорж, Нанзаддорж. 2002. *Төрийн онол*. Улаанбаатар: Адмон.
- Лхамсүрэн, Ойдов. 2002. *Чингис хааны Их засаг хууль*. Улаанбаатар: Урлах эрдэм. Монгол Улсын их сургууль. 2003. *Монгол Улсын түүх*. Улаанбаатар: МУИС пресс.
- Монгол Улсын их сургууль. 2017. *Монгол Улсын түүх*. Ред. Дэлгэржаргал П., Болдбаатар Ж. Улаанбаатар: МУИС пресс.
- Өлзийбаяр, С. 2017. “Эртний нүүдэлчдийн нийгмийн байгууллын зарим асуудалд: Було/Бүл.” *Угсаатан судлал Totius XXV: 44-65*.
- Плано Карпини. 2006. *Монголчуудын түүх*. Орч. Нямаа Л. Улаанбаатар: Интерпресс.
- Рязановский В.А. 2002. *Чингис хааны Их засаг хууль*. Улаанбаатар: Урлах эрдэм.
- Сайшаал. 2010. *Чингис хааны товчоон I*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Соёл, урлаг судлалын хүрээлэн. 2006. *Монголын соёл судлалын асуудлууд*. Ред. Сумъяа Б. Улаанбаатар.
- Соёл, урлаг судлалын хүрээлэн. 1999. *Монголын соёлын түүх I*. Эрх. Сумъяа Б. Улаанбаатар: Адмон.
- Сумъяа, Буд. 2001. *Монголын нүүдэлчдийн соёл: Ориших эс ориших*. Улаанбаатар: Адмон.
- Сүхбаатар, Гүнж. 1980. *Монголчуудын эртний өвөг*. Улаанбаатар: ШУА, Түүхийн хүрээлэн.

- Сыма Цянь. 2014. *Хүннүгийн шастир: “Сыма Цяний “Ши цзи” зохиолын 110-р бүлэг*. Орч. Элдэв-Очир Г., Ганбаатар Я. Улаанбаатар: ШУА, Археологийн хүрээлэн.
- Сэнгэдорж, Тэгшжаргал. 2002. *Монгол Улсын газрын эрх зүй*. Улаанбаатар: МУИС пресс.
- Шагдаржав, Г. 2008. *Монгол төрийн тэргүүн: Хүннүгийн шаньюйгаас Монгол Улсын ерөнхийлөгч*. Улаанбаатар: Адмон.
- Энхтүвшин, Батболд. 2021. *Иргэнийл ба нийгмийн хөгжил VIII*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Эрдэнэбаатар, Д., Мижиддорж, Э., Идэрхангай, Т. ба бус. 2021. *Хүннүгийн язгууртны булины судалгаа. Балгасын тал дахь “Гол мод” 2*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- 司马迁. 无日期. 《史记》匈奴列传. [www.zhonghuadiancang.com/lishizhuanji/shiji/1522.html](http://www.zhonghuadiancang.com/lishizhuanji/shiji/1522.html).